

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
СПОРТЫН ХЭЛТЭСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Сүхбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэлж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
Зорилго-1.Идэвхтэй амьдралын хэв маягтай иргэдийн тоог нэмэгдүүлэх							
Зорилт-1.1 Ард иргэд, хүүхэд, залуучуудыг биеийн тамирын арга хэмжээгээр дамжуулан бэлдэржүүлэх, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх, хөдөлгөөний, дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт суртах насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамирын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх							
1	Арга хэмжээ-1.1.1 Сэлэнгэ бага олимп Хүүхдийн спортын наадмыг зохион байгуулж, спортын зарим төрлүүдээр улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг аймагтаа зохион байгуулах	6,5 сая	Хамрагдсан хүний тоо	3	4	Аймгийн хэмжээнд 175 секц дугуйланд 4550 тамирчин хичээллэж аймгийн аварга шалгаруулах 16 тэмцээнд 1351, улсын аварга шалгаруулах 22 тэмцээнд 384 тамирчинг, аймагт хүлээн авсан 3 улсын аварга шалгаруулах тэмцээнд 1584 тамирчин оролцуулан 28 алт 57 мөнгө 49 хүрэл, Монголын хүүхдийн спортын наадмын шигшээ тэмцээнд 237 тамирчинг спортын 23 төрлөөр оролцуулан 8 алт 5 мөнгө 14 хүрэл медаль Хөгжлийн бэршээлтэй 3 төрлийн тэмцээнд 10 тамирчинг оролцуулан 1 алт, 2 мөнгөн хүртсэн амжилтыг үзүүлсэн.Нийт 35 алт 66 мөнгө 63 хүрэл бүгд 164 медаль хүртэж медалийн чанрыг 20.7 хувиар өсгөсөн. Аймгийн шигшээ багийн тамирчдаас ОУлсын 4 тэмцээнээс / Бокс, чөлөөт бөх/ 1 мөнгө, 1 хүрэл Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 хүрэл	82,5

2	Арга хэмжээ-1.1.2 Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн спортыг дэмжиж мэргэжлийн түвшинд өрсөлдөх тамирчдыг нэмэгдүүлж, амжилтыг үнэлэх.	1 700 000	Хамрагдсан хүний тоо	0	500	Медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Хагас жилд аймаг, улсын аварга шалгаруулах 61 тэмцээнд 1972 тамирчин, аймагт хүлээн авч зохион байгуулсан 3 удаагийн УАШТэмцээнд 1584 тамирчин дэлхийн аварга, гадаадын 3 тэмцээнд 13 тамирчинг хамруулж, нийтийн биеийн тамирын 134 арга хэмжээнд спортын 16 холбоо, 68 аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиглаа. Волейболын спортын төрлөөр манай аймгийн 2 тамирчин, буудлагын спортын төрлөөр 1 тамирчин Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор улсын шигшээ хичээллэж байна. ХСпортын наадамд Спортын 22 холбоодоос 17 холбоо нь хамтран ажигласан. Энэ онд модон барилдааны "Хүдэр хүчтэн" холбоо шинээр нэмэгдсэн.	97,2
3	Арга хэмжээ-1.1.3 Өвлийн болон багийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилтыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ.		Хамрагдсан хүний тоо			"Хөдөлгөөнөөр эрүүлжбэ" өвөл цагийн биеийн тамирын арга хэмжээг олс таталт, гийр өргөлт, сүмо бөхийн төрлөөр 02 дугаар сарын 22-ний өдөр Сүхбаатар сумын 5-р баг, Хөдөө нуурт зохион байгуулж нийт 11 байгууллагын эрэгтэй 66, эмэгтэй 66 нийт 132 албан хаагч хамрагдсан. Бүх нийтийг хамарсан Биеийн тамир, спортын арга хэмжээг "Өөртөө Цаг гарга" уриан дор спорт холбоо, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 195 арга	

						хэмжээнд 36,552 иргэнийг хамруулсан.	
4	Арга хэмжээ-1.1.4 Шигшээ багийн үйл ажиллагааг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлэх	4 000 000	Хамрагдсан хүний тоо	6421	6600	Монгол улсын Засгийн газрын 183 дугаар тогтоолын дагуу хатас жилд Монголын Хүүхдийн Спортын VIII наадмын анхан шатны тэмцээнийг 14 төрлөөр 3684 тамирчинг оролцуулан анхан шатны бүртгэлд бүртгэж Аймгийн шигшээ багыг бүрдүүлэн шигшээ тэмцээнд 237 тамирчин 23 төрлөөр шалгаран оролцож 9 төрөлд 9 алт 7 мөнгө, 14 хүрэл медаль хүртэж багаараа шагналт 6 дугаар байранд шалгарсан.	100
5	Арга хэмжээ-1.1.5 Спортын сурталт-дасгалжуулалт, орчин, хэрэглэл материалын стандартуудыг сайжруулан аймгийн хэмжээнд спортын төрлийн стандартын техник хэрэгслийг нэмэгдүүлэн сурталчилах ажлыг зохион байгуулах	1 455 000	Хамрагдсан хүний тоо	0	130	Аймгийн хэмжээнд өвлийн спорт цана, хоккейн спортуудыг суурь баазад нь тулгуурлан Түнхэл, Бугант, Хүдэр суманд хөгжүүлж уг спортын төрлүүдэд 120 хүүхэд, залуучууд, ахмадууд хичээллэж байна. Цана, хоккейн спортуудад хичээллэхэд спортын хэрэгсэл нь өртөг өндөртэй спорт учраас эдийн засгаас шалтгаалан хүүхэд, залуучууд сонирхол ихтэй ч хичээллэх боломж нөхцөл муу байна. 2025 онд Хүүхдийн спортын VIII дугаар наадамд 2 насны ангиллаар 28 тамирчинг оролцуулан шигшээ тэмцээнд бага нас 4 байранд, том нас 5 дугаар байранд шалгарсан амжилтыг үзүүлсэн. Цанын спортын төрлөөр насны ангиллаар 6 тамирчинг оролцуулан бага насны ангилалд тамирчин Х.Шинээ 500, 1500 м 2	100

						зайд мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Ерөө кап мөсөн сурын тэмцээнийг Ерөө суманд зохион байгуулан 6 клуб, 8 аймгийн 230 гаруй тамирчид оролцсон. Сүхбаатар сумын ЗДТГазартай хамтран "Сэлэнгийн мөнгөн өвөл" баярыг хөдөө нууран дээр зохион байгуулж 36 аж ахуйн нэгж байгууллагын 1240 гаруй албан хаагчид, иргэдийг оролцуулсан. Олон улсын стандартад нийцсэн 2000 хүний суудалтай орчин үеийн шийдэлтэй соёл спорт "Сэлэнгэ арена" цогцолборын зураг төслийн асуудлыг шийдвэрлэн гаргаж, газрын асуудлыг шийдвэрлэсэн.	
6	Арга хэмжээ-1.1.6 Ахмадуудын дунд спортын төрлөөр арга хэмжээг зохион байгуулах					Усанд сэлэлтийн Мастерсийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд 17 байгууллагын 178 тамирчин, Хүдэр сумын Заагаг даргын нэрэмжит Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд 9 сум, 2 тосгоны 20 багийн 170 тамирчин оролцсон Аймгийн аварга шалгаруулах софт волейболын тэмцээнийг Сайхан суманд зохион байгуулж 5 сумын 18 багийн 90 гаруй тамирчин, нийт 3 төрлийн арга хэмжээнд 438 ахмадуудыг хамруулсан	-
		-	Хамрагдсан хүний тоо	460	500		
	Арга хэмжээ-1.1.7 Шинээр хөгжиж буй төрлүүдийг дэмжин мэргэжил арга зүйн удирдлагааг хангах	3000000	Хамрагдсан хүний тоо	Тий болын төрөл	0	Шинэ тутам хөгжиж байгаа грангольф, кронхол, дардас, модон барилдаан зэрэг 4 төрлийн спортыг хөгжүүлэн 2 секц дуулилан нэмэгдэж спортын 2 холбоотой	

						болсон. Кронхол, Дардас, Модон барилдааны холбоотой хамтран аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан улсын тэмцээн наадамд оролцуулан модон барилдаанаар өсвөр залуучуудаас 2 алт 3 мөнгө 2 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн байна. Тийбол, спорт өрөлтийн спортыг хөгжүүлэх чиглэлээр Тийболын улсын сургалтанд 4 арга зүйч, 1 багш, оюуны спорт өрөлтийн спортыг Оюун ухааны академтэй хамиран хөгжүүлж Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 2 насны ангиллаар тэмцээнийг зохион байгуулсан. Мөн Тийболын улсын аварга шалгаруулах тэмцээнд Аймгийн засаг даргын дэмжлэгтэйгээр Сайхан, Хушаат сүмийн 2 баг амжилттай оролцсон.	
7	Арга хэмжээ-1.1.8 Усан спортоор хүүхэд, залуучууд, иргэдийг хичээллэх боломжоор ханган усан сэлэлтийн тэмцээнийг зохион байгуулах					Усан спортоор хүүхэд, залуучуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, иргэн бүрт сэлэлтийн техник зааж сургах чиглэлээр 2 удаа аймгийн болон Сүхбаатар сумын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулан түүнд аж ахуй нэгж 27 байгууллагын 82 тамирчин оролцсон. Улсын хэмжээний ОБГ-аарын эрэн аврахын 51 албан хаагчдад 14 хоногийн сургалтыг зохион байгуулж, хагас жилд усан спортоор үйлчлүүлж байгаа 567 иргэдэд усан спортын мэдээлэлээр	

						Хангаж, анхан шатны мэдлэгийг зааж сурган заавар зөвлөмжийг өгч ажиллаж байна. Усан сэлэлтийн насанд хүрэгч, ахмад Мастерсийн Улсын аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа хүлээн авч Монголын усан спортын холбоотой хамтран зохион байгуулж тэмцээнд нас тус бүрт аймаг хот дүүргийн 17 багийн 167 тамирчин оролцож манай аймгийн баг тамирчид 4 мөнгө, 9 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Орхон аймагт болсон өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 28 тамирчин оролцуулан 2 алт 3 мөнгө 12 хүрэл медаль хүртэж, ХСпортын VIII наадмын усан спортын тэмцээнд багийн төрлөөр хүрэл медаль хүртсэн.	
8	Арга хэмжээ-1.1.9 Ахмадын нас биеийн онцлогт тохирсон биеийн тамирын арга хэмжээг улирал бүр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягт уриалж дэмжлэг үзүүлэх	2 500 000	Хамрагдсан хүний тоо	-	-	Усанд сэлэлтийн Мастерсийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд 17 байгууллагын 178 тамирчин, Хүдэр сумын Загаг даргын нэрэмжит Аймгийн аварга шалгаруулах волейболын тэмцээнд 9 сум, 2 тосгоны 20 багийн 170 тамирчин, Аймгийн аварга шалгаруулах софт волейболын тэмцээнийг Сайхан суманд зохион байгуулж 5 сумын 18 багийн 90 гаруй тамирчин, нийт 3 төрлийн арга хэмжээнд 438 ахмадуудыг хамруулсан.	100

Зорилго-2 "Спортлог Сэлэнгэчүүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Зорилт-2.1 "Спортлог Сэлэнгэчүүд" хөтөлбөрийн хүрээнд аймгийн иргэдийн дунд насны ангиллаар, биеийн тамирын арга хэмжээг хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах

1	Арга хэмжээ-2.1.1 "Сэлэнгэ Марафон" гүйлтийн арга хэмжээг зохион байгуулах	21 000 000	Хамрагдсан хүний тоо	454	500	"Сэлэнгэ Марафон-2025" бүх нийтийн гүйлтийн арга хэмжээг Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/274 дугаар тоот захирамжийн дагуу ажлын хэсэг байгуулагдан 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдөр амжилттай зохион байгуулж Сэлэнгэ аймаг, орон нутгаас нийт 1950 оролцогч оролцсон.	100
2	Арга хэмжээ-2.1.3 Хүн амын амьдралын хэв маяг идэвхтэй хөдөлгөөний мэдлэг, хандлага, дадалтай иргэдийн тоот нэмэгдүүлэх зорилгоор "Иргэдийн спортын их наадам"-ыг 17 сумын иргэдийн дунд 3 үе шаттай зохион байгуулах	19 780 000	Хамрагдсан хүний тоо	0	0	Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн, Биеийн тамир спортын Улсын хорооны даргын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Спортын наадам зохион байгуулах тухай 1/250 тоот бичгийн дагуу Иргэдийн спортын их наадмын анхан шатны тэмцээнийг спортын 7 төрөлд Сэлэнгэ аймгийн 5 бүсэд зохион байгуулсан. Анхан шатны тэмцээнээс шалгарсан иргэдийн дунд Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/220 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 05 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулж Төвийн бүсэд аймгаа төлөөлөн оролцох 127 тамирчныг сонгон шалгаруулсан. Аймгаас шалгарсан 127 тамирчин Дархан-Уул аймагт 2025 оны 05 дугаар сарын 28-30-ний өдрүүдэд Төвийн бүсийн тэмцээнд оролцож	100


3	Арга хэмжээ-2.1.4 Хөгжлийн иргэдийн дунд биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулах					Улаанбаатарын бүсийн шигшээ тэмцээнд Төвийн бүсээс Сэлэнгэ аймгаа төлөөлөн 49 тамирчин оролцохоор шалгарсан.	
						Засаг даргын тамгын газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран "Бид хамтдаа" спортын 5 төрөлт тэмцээнийг 05 дугаар сарын 10-11-ны өдрүүдэд Хүдэр сумын спорт цогцолборт зохион байгуулж 15 сум, 2 тосгоны нийт 170 иргэнийг хамруулсан.	
		3 000 000	Хамрагдсан хүний тоо	120	150	2025 оны ХБИргэдийн ХСпортын үйл наадамд парахөнгөн, бочи, диф даам, диф сагсан бөмбөг зэрэг спортын 4 төрлөөр 12 тамирчинг оролцуулан 1 алт, 2 мөнгөн медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоотой хамтран спортын 4 төрлөөр / суугаа волейбол, паражудо, парахөнгөн, ширээний теннис, / 30 гаруй тамирчинг сургалтанд тогтмол хамруулан хичээллэж байна.	

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар	Хувь
1	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Төрийн албаны зөвлөл, БТСУХ, ЗДТГ, Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, далагдан	Сургалтад хамрагдсан байна	-	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2025 оны 05 дугаар сарын 24-ны өдөр Сэлэнгэ аймагт зохион байгуулсан Төвийн бүсийн бүсчилсэн зөвлөгөөнд	100

	гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, цаг үеийн шинжтэй зохион байгуулагдах сургалтад хамрагдах			оролцсон. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар, Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын газраас хамтран зохион байгуулсан "Ажил олгогчдын зөвлөгөөн-2025"-д оролцсон.	
2	Арга зүйчдийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зохион байгуулалтад оролцуулж ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах	Арга хэмжээг зохион байгуулж, сургалтад хамрагдсан байна	-	"Иргэдийн спортын их наадам"-ын аймгийн сонгон шалгаруулах тэмцээн 2025 оны 05 дугаар сарын 16-18-ны өдөр, "Сэлэнгэ Марафон-2025" бүх нийтийн гүйлт 2025 оны 06 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулагдаж тус 2 арга хэмжээний зохион байгуулалтад арга зүйчдийг оролцуулж ажиглуулсан.	100
3	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирлаар гаргуулж дүгнэх, урамшуулах	Биелэлтийг зөв гаргаж сурсан байна	-	Арга зүйчийн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг газрын даргаар батлуулж улирал бүр биелэлт, статистик мэдээг хэрхэн гаргах талаар мэдээлэл өгч, төлөвлөгөөний биелэлтийг гаргуулж, хянан, үнэлгээ өгч урамшуулсан.	100

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
СПОРТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



А.ЭЛБЭГБАЯР

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

---000---